



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/253

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.10 дахь заалтууд, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.11.1 дэх заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 04 сарын 23-ны өдрийн 7 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1.Аймгийн хэмжээнд "Татвар төлөгчдийн өдрүүд-2026" арга хэмжээг 2026 оны 05 дугаар сарын 04-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Арга хэмжээний зардалд шаардагдах 16000000 (арван зургаан сая) төгрөгийг батлагдсан төсвөөс гаргахыг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д. Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3.Зохион байгуулах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, үр дүнг 2026 оны 05 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд тайлагнахыг аймгийн Татварын газар (Н. Энхтуяа)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:zahiramjZax ZD 2026

8000090481

